

ГЛОБАЛЧЛАЛ ХИЙГЭЭД МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ АСУУДЛЫГ ХӨНДӨЖ БИЧСЭН НЭГЭН ШИНЭ БҮТЭЭЛИЙН ТУХАЙ

*Ц.Гүрбадам**

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, эдийн засгийн шинжлэх ухааны доктор, профессор Ц.Баатарын туурвисан “Глобалчлалын эриний Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцаа” гэсэн бүтээл саяхан хэвлэлээс гарч судлаачдын анхаарал сонирхолыг татсаар байна. Судлаач сүүлийн үед Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйлсэд ихээхэн анхаарал хандуулж энэ чиглэлээр дагнан судалгаа хийж 2005 онд англи хэлээр “Economic Globalization: External Factors of Mongolian Development “ хэмээх бүтээл хэвүүлсэн билээ. Энэ номын шууд үргэлжлэл гэж хэлж болох дээрхи бүтээлдээ зохиогч глобалчлал хэмээх цоо шинэ үзэгдэл бүхэл бүтэн эринд дотоод гадаад үй түмэн хүчин зүйлсийн олон тооны үл мэдэгдэхүүний орчинд Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцаа “Олон тулгуурт нээлттэй гадаад бодлого”-ын хүрээнд хэрхэн өөрчлөгдөн шинэчлэгдэж, шинэ шинэ агуулга, хэлбэрээр баяжин өрнөн хөгжиж байгааг анх удаа цогц байдлаар авч үзэж, түүний өнөөгийн төлөв байдал, цаашдын чиг хандлагыг нээн харуулахаар оролдсон нь хувь хүний хувьд хийсэн нэн зоригтой алхам гэлтэй.

Зохиогч бүтээлээ туурвихдаа дотоод гадаадын эрдэмтэн судлаачдын 248 гаруй бүтээлээс эш татаж, бүтээлийнхээ санаа дүгнэлтийг баталгаажуулах үндэслэл болгон шигтгэн ашиглажээ.

Ц.Баатарын бүтээлийг манай нэртэй эрдэмтэд болох академич Т.Дорж, эдийн засгийн шинжлэх ухааны доктор, профессор Г.Цэдэндагва нар шүүн тунгааж, хянан найруулсан нь уг бүтээлийн шинжлэх ухааны түвшин, чанар, чансаа ямар болохыг илэрхийлэх нэгэн ёсны үзүүлэлт буй заа.

Глобалчлал гэсэн нэр томъёо гэхэд л бид бүгд нэгдсэн нэг ойлголттой болж чадаагүй байгаа бөгөөд “глобалчлал”, “даяршил”, “даярчлал”, “дэлхийчлэл”, бөмбөрцөгчлэл гэх мэтээр ярьж бичсээр байна. Тэгвэл түүний мөн чанар, зүй тогтол, ирээдүйн эерэг болон сөрөг үр дагавар ямар байхыг гүйцэд сайн ойлгоогүй байгаа маань нууц зүйл биш ээ.

Иймд эдийн засаг, шинжлэх ухааны чадавхи сул, шилжилтийн эдийн засагтай, хүн ам цөөнтэй, өчүүхэн зах зээлтэй, түүхий эд

* Ц.Гүрбадам - МУИС-ийн Олон улсын харилцааны сургууль, доктор (Sc.D), профессор

экспортлодог, глобал эдийн засгаас хол хөндий, тэрч бүү хэл бүс нутгийн ямарч интеграцид нэгдэн нийлээгүй Монгол шиг жижиг улс энэхүү глобалчлалыг бурханчлан шүтэх үү, буг чөтгөр хэмээн айж зугатах уу гэсэн нэг том асуулт, тодорхойлоход бэрх үл мэдэгдэхийг судлан ойлгох шаардлага эрдэмтэд, эдийн засагчид, улс төрчдийн өмнө хурцаар тавигдаад байна. Энэ талаар судлаач Ц.Баатар номондоо: “Монгол Улс өнөөдөр глобалчлалыг зөвхөн урсгалаар нь хүлээн авч байна. Энэ байдлыг гэтлэн давахын тулд глобалчлалын чиг хандлагыг нарийн мэдэрсэн алсын хараатай төрийн стратеги бодлого нэн чухал” гэж цохон тэмдэглэжээ.

Глобалчлалын үйл явцаас авууштай нэн дэвшилттэй олон зүйл байгааг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байгаа билээ. Глобалчлалын зарим эерэг үр дагавар манай улсад ч нэвтэрч эхлээд байгаа ч болгоомжлох бодлоготой хандах зүйлс ч бас бий. Ингэж хандах, бүр эсэргүүцэн тэмцэх явдал өндөр хөгжилтэй орнуудад их хүчтэй өрнөж байгааг бүгд мэдэж байгаа билээ.

Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, профессор Ц.Баатар глобалчлалыг хэрхэн үзэж байгаагаа “Глобалчлалын үйл явц нь зохицуулалттай хяналтад амархан автдаггүй бөгөөд уламжлалт “зохистой зааг хүрээг” эвдлэн гарч, янз бүрийн соёлын интеграцлалтай холбогдсон бэрхшээл, санхүүгийн эмх замбараагүй байдлыг бий болгож байна” хэмээн тодорхойлжээ.

Түүнчлэн зохиогч энэхүү бүтээлдээ Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцаанд глобал орчны хүчин зүйлсийн нөлөөллийг шинжилж, манай орны хувьд түүхийн аль ч үеийн туршид чухал байр суурь эзэлсээр ирсэн, Орос, Хятадын хүчин зүйлийг авч үзэж, манай гурван орны худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг тодорхойлж, нээлттэй эдийн засагт үндэсний эдийн засгийн өсөлт хөгжлийг хангах, хөрөнгө оруулалт, экспортын бүтцийн загварыг математик аппаратын тусламжтайгаар томъёолсон нь бүтээлийн нэгэн шинэлэг тал, түүний үнэ цэнийг өргөх нэгэн хүчин зүйл болжээ.

Глобалчлалын өнөөгийн эрин зөвхөн санхүү, валютын урсгал төдийгүй бусад олон асуудлын хүрээнд эмх замбараагүй байдал бий болгож тэр нь улам бүр газар авч байна. Энэ эмх замбараагүй байдлаас Монгол улс өөрийгөө хэрхэн хамгаалах вэ гэсэн асуулт зүй ёсоор тавигдах учиртай. Тийм хамгаалалт бий болгох бодитой арга зам бол ОХУ, БНХАУ-ын хүчин зүйл гарцаагүй мөн. Энэ асуудлыг зохиогч номондоо голчлон өнөөгийн түвшинд авч үзсэн хэдий ч “Монгол-Орос-Хятад” гэсэн “хөгжлийн гурвалжин” байгааг дурдаад манайх шиг

жигжиг орныг бодлогоор дэмжиж, өсөлт хөгжлийн хүчирхэг хөшүүрэг болж, дэлхий нийтийн анхаарлыг татах түүхэн боломж хоёр хөршид маань бий гэж дүгнэсэн байна.

Энэ нь туйлын чухал зөв санаа. Учир гэвэл агуулга нь тун бүдэг байгаа глобалчлалын эрин үед манай улс умард хөрш, өмнөдийг дамжин ирж болзошгүй глобалчлалын их давалгаанаас Монгол Улсаа хамгаалах бат бэх найдвартай “хэрэм” хоёр хөрш маань байх болно. Элдвийн бодлогогүй гоомой алхам, гуйвж дайвсан “маневерчлал” хийгээд хоосон улс төржөөд байвал бид бүгд хожих бус, хохирох л болно.

Глобалчлал гэдэг нь зүйрлэж хэлэхэд их далайн хар шуурга-тайфун, цунами мэт бөгөөд учир битүүлэг, тааварлахад бэрх үзэгдэл бөгөөд умард, өмнөд хөршүүдийн хил өөрөөр хэлбэл усан санг хашдаг даланг сэт дайраад манайд орж ирвэл юу болохыг өнөөдөр төсөөлөхөд бэрх.

Энэ мэт олон зүйл, эрэгцүүлэл, бодрол, таамаглал төрүүлсэн “Глобалчлалын эриний Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцаа” хэмээх нэгэн сэдэвт шинэ бүтээлийг эрхэм хүндэт абугай нар уншвал хайран цагаа алдлаа гэж харамсахгүй, харин ч шинэ сонин зүйл мэдэж авлаа хэмээн баясах болно гэдэгт эргэлзэхгүй байна.